



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 21 өдөр

Дугаар А/39

Чингис хот

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 156 дугаар тогтоол, Улсын онцгой комиссын 2021 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 303 дугаар “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичиг, аймгийн Онцгой комиссын 2021 оны 02 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт ажиллаж байгаатай холбогдуулан Улаанбаатар хотод хязгаарлалтын дэглэмд орсон, орон нутагтаа буцах хүсэлт гаргасан иргэдийг нэвтрүүлэх ажлын хэсгийг доор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн
ахлагч:

Ж.Эрдэнэбат

Онцгой байдлын газрын дарга,
дэд хурандаа

Нарийн бичгийн
дарга:

Б.Бат-Эрдэнэ

Гамшгаас хамгаалах төлөвлөлт бэлэн
байдал хариуцсан ахлах мэргэжилтэн,
ахлах дэслэгч

Гишүүд:

Б.Ганбат

Авто тээврийн төвийн дарга

Б.Батсайхан

Цагдаагийн газрын дарга, цагдаагийн
хурандаа

М.Шүрэнцэцэг

Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд
Чингис хотын захирагч

Л.Мэндбаяр

Эрүүл мэндийн газрын дарга

Г.Наранхүү

Зооноз өвчин судлалын төвийн дарга

Н.Мөнхчимэг

Мэргэжлийн хяналтыг газрын Эрүүл
мэнд, боловсрол, хүнсний хяналтын
хэлтсийн дарга

Ч.Батгэрэл

Цахилгаан холбооны газрын дарга

Н.Алтангэрэл

Тагнуулын ерөнхий газрын харьяа
Хэнтий аймаг дахь хэлтсийн дарга,
дэд хурандаа

231010131

2.

2. Орон нутагтаа буцах хүсэлт гаргасан иргэдийг нэвтрүүлэх ажлыг 2021 оны 01 дүгээр сарын 23-ны өдрөөс эхлэн зохион байгуулан явуулсугай.

3. Дамжин өнгөрч байгаа зорчигч тээврийн хэрэгслийн шатахуун авах цэгийг Жаргалтхаан, Хэрлэн сумын Хэрлэнгийн гүүрний урд байрлах зам дагуух шатахуун түгээх станцууд, зорчигчдыг өөрсдийн бэлтгэсэн хоол хүнсийг хэрэглэх, бие засах цэгийг Цэнхэрмандал сумын нутаг Хэрлэн голын гүүрнээс урагш Дэлүүн болдог үйлчилгээний төвийн талбай, Жаргалтхаан сумын угтах хаалга, Чингис хотод Авто тээврийн төвийн зогсоолд тус тус байгуулсугай.

4. Заасан цэгт зорчигчдын хог хаягдал хаях, бие засах газрыг байгуулах, сэжигтэй тохиолдлыг тусгаарлах байрны бэлтгэл, бэлэн байдлыг хангаж ажиллахыг Цэнхэрмандал, Жаргалтхаан, Мөрөн, Хэрлэн сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5. Улаанбаатар хотоос ирсэн иргэдийг бүртгэн 14 хоног гэрийн ажиглалтад авч, хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн газар /Л.Мэндбаяр/, Цагдаагийн газар /Б.Батсайхан/, Тагнуулын хэлтэс /Н.Алтангэрэл/, Мэргэжлийн хяналтын газар /Б.Сүнгээ/, сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

6. Зорчигчдыг орон нутагт нэвтрүүлэх, хуваарь гаргах албан хаагчдыг хавсралтаар баталсугай.

7. Засгийн газрын 2020 оны 156 дугаар хавсралтаар батлагдсан "Түр журам батлах тухай" тогтоолыг хэрэгжүүлэн, халдвар хамгааллын дэглэмийг чанд баримталж ажиллахыг ажлын хэсэг /дэд хурандаа Ж.Эрдэнэбат/, энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Онцгой комиссын орлогч дарга /Ц.Чогсомжав/ нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

УЛААНБААТАР ХОТООС ИРГЭДИЙГ ТАТАН АВАХАД
АЖИЛЛАХ АЛБА ХААГЧДЫН НЭРС

д/д	Байгууллага	Нэрс	Албан тушаал
1	Онцгой байдлын газар	Г.Одхүү	Хэрлэн сум дахь Гал түймэр унтраах аврах 32 дугаар ангийн салааны захирагч, ахмад
2		Б.Баттүшин	Нягтлан бодогч, ахлах дэслэгч
3		О.Минжбадгар	Шуурхай удирдлагын оператор, ахлагч
4	Мэргэжлийн хяналтын газар	Ц.Бат-Эрдэнэ	Тээвэр /өргөх механизм/-ын хяналтын улсын байцаагч
5		Г.Бүжмаа	Эрүүл ахуйн халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч
6		Д.Баттулга	Барилгын техникийн хяналтын улсын байцаагч
7	Хэрлэн сумын ЗДТГазар	З.Алтантөгс	Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн
8		Т.Алтантуяа	Мал үржлийн тасгийн дарга
9		Э.Чулуунбат	Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн
10	Цагдаагийн газар	Д.Хүрэлбаатар	Шүүх, шүүгчийн аюулгүй байдал хариуцсан ахлах байцаагч, цагдаагийн хошууч
11		Н.Эрдэнэбулган	Замын зохицуулагч цагдаа, цагдаагийн дэд ахлагч
12		Г.Бадрал	Эргүүлийн офицер, цагдаагийн дэслэгч
13	Авто тээврийн төв	Р.Ганхүү	Тээвэр зохицуулагч
14		Ч.Байгалмаа	Тээвэр зохицуулагч
15		Ш.Эрдэнэчимэг	Тээвэр зохицуулагч
16	ЗӨСТөв	Ц.Ууганбаяр	Биологич
17	Эрүүл мэндийн газар	О.Энх-Уянга	Эмийн чанар аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн
18		Г.Алтансүвд	Өсвөр үеийг хариуцсан мэргэжилтэн
19	Цахилгаан холбооны газар	Н.Номин-Эрдэнэ	Үйлчилгээний ажилтан